



ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/43

Бэрх хот

Дэмжлэг үзүүлж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дах заалт, Захирагчийн Зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн №04 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус хотын иргэн ГТУА 42 дугаар ангийн Аврагч гал сөнөөгч Ахлах ахлагч Доржсүрэнгийн Дэлгэрсайханы гэрт гал гарч, эд хөрөнгө, өрхийн хэрэглээний зүйлс бүрэн шатсан тул дэмжлэг үзүүлж 500.000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дэмжлэгт шаардагдах 500.000 (Таван зуун мянга) төгрөгийг Захирагчийн эрсдэлийн сангаас холбогдох хууль, дүрэм, журмын дагуу гаргахыг нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (П.Янжмаа)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ



Ч.ЭНХЖАВХЛАН

232501043